

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагагын тухай хуулиас...

СУМЫН ЧИГ ҮҮРЭГ

- сумын чиг үүрэгт дараах асуудал хамаарна:
- сумын хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт;
- сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;
- сумын төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлан, хяналт;
- хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хэмжээг тогтоох асуудал;
- сумын орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;
- аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл;
- аймгийн хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт;
- сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;
- худалдаа, үйлчилгээний зохион байгуулалт, хяналт;
- орон сууц, нийтийн аж ахуйн удирдлага;
- суурин газрын замын хөдөлгөөн, авто зогсоолын зохицуулалт;
- хөшөө дурсгалын байршил, хамгаалалт;
- нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн ашиглалт, хамгаалалт;
- аялал жуулчлалын үйл ажиллагааны зохицуулалт;
- хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлын менежмент;
- оршуулгын газрын үйл ажиллагааны зохицуулалт;
- сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;
- гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу, арчлалт;
- орон нутгийн цэвэрлэх байгууламжийн арчлалт;
- орон нутгийн зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт;
- суурин газрын гэрэлтүүлэг, арчлалт.
- бэлчээрийн ашиглалт, хамгаалалт.